



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 06 сарын 28 өдөр

Дугаар 76

Номгон

Ядамын Бадамжавын хөшөөг
байгуулахыг дэмжих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12, Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Хуучнаар Сайн ноён хан аймгийн Дайчин вангийн хошуу одоогийн Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын харъяат, Манжийн дарангуйлал, феодалын эсрэг тууштай тэмцэн ядуу ардыг ивээн тэтгэгч, олноо шилийн сайн эр хэмээн дээдлэгддэг Хундан хэмээх Ядамын Бадамжавын хөшөөг түүний төрсөн нутаг тус сумын Сэнжит 1 дүгээр багийн төвд байгуулах санаачилгыг дэмжсүгэй.

2. Ядамын Бадамжавын хөшөөг байгуулсантай холбогдуулан ажил үйлсийг нь хойч үеийнхэнд таниулж, гавьяат үйлсийг нь алдаршуулан ажиллахыг сумын Засаг дарга /Ц.Төмөрбаатар/-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР